



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2017 оны 07 сарын 06 өдөр

Дугаар А/369

Булган

Хуулийн хэрэгжилтийг  
хангуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 /а/, 29.1.6 /в/ заалт, Сонгуулийн тухай хуулийн 96 дугаар зүйлийн 96.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хоёр дахь санал хураалтын өдөр буюу 2017 оны 07 дугаар сарын 07-ны өдөр согтууруулах ундааны худалдаа, үйлчилгээ явуулахгүй байхыг тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үүрэг болгосугай.

2. Соёл урлаг, үзвэр, спорт, баяр наадам, өдөрлөг зэрэг олныг хамарсан аливаа арга хэмжээ зохион байгуулахгүй байх, гадаа болон битүү талбайд үйл ажиллагаа явуулдаг худалдаа, үйлчилгээний төвүүдийг ажиллуулахгүй байх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, хяналт тавихыг сумын Засаг дарга нарт даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар /З.Гомбо/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ